

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/61/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Shinjlenmagadlahui.ezshaudit.mn
Улаанбаатар хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn
Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК
Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 105
танай _____ -ны № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МУЗЕЙН
ДАРГА Д.ЖАМБАЛДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Музейн 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 88.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх Нийгмийн даатгалын шимтгэл, 0.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамжийн материал 4.6 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардал 1.8 хувийг, албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэгт 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020145

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 40 хувиар өссөн байна

Бусад асуудал

Дархан-Уул аймгийн Музей нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын 65 нэр төрлийн арга хэмжээ төлөвлөж, 416 удаагийн үйл ажиллагааг хэрэгжилтийг 99.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,915,479.64	7,329,530.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	144,579.64	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	144,579.64	-
3121	Төгрөг	144,579.64	-
31211	Төрийн сангийн харилцах	144,579.64	-
35	БАРАА МАТЕРИАЛ	7,770,900.00	7,329,530.00
354	Хангамжийн материал	7,770,900.00	7,329,530.00
35420	Аж ахуйн материал	3,621,400.00	3,621,400.00
35440	Түлш, шатах тослох материал	120,000.00	71,630.00
35470	Бусад хангамжийн материал	4,029,500.00	3,636,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,013,740,552.28	1,055,263,549.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,013,740,552.28	1,055,263,549.24
392	Биет хөрөнгө	921,832,552.28	963,355,549.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	287,759,200.00	287,759,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,892,205.40)	(44,270,646.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,545,172.88	89,804,318.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,264,084.45)	(19,525,038.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,922,359.00	7,244,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,660,704.75)	(728,899.10)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	623,019,100.00	640,669,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	750,000.00	750,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(750,000.00)
39217	Ном	2,403,215.00	2,403,215.00
393	Биет бус хөрөнгө	91,908,000.00	91,908,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	91,908,000.00	91,908,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,021,656,031.92	1,062,593,079.24
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,021,656,031.92	1,062,593,079.24
51	Засгийн газрын хувь оролцоо	1,021,656,031.92	1,062,593,079.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,893,504.40	181,893,504.40
51101	Өмч: - төрийн	181,893,504.40	181,893,504.40
512	Хуримтлагдсан үр дүн	47,662,263.93	88,599,311.25
51210	Өмнөх үеийн үр дүн	1,022,435.69	47,662,263.93
51220	Тайлант үеийн үр дүн	46,639,828.24	40,937,047.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	792,100,263.59	792,100,263.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,021,656,031.92	1,062,593,079.24

ХТ05430 @ 9672890

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	333,545,710.60	440,068,334.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,991,573.13	70,510,355.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,991,573.13	70,510,355.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,998,490.00	23,995,520.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,698,490.00	23,995,520.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,300,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	30,993,083.13	46,514,835.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	274,554,137.47	369,557,835.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	255,022,137.47	352,482,979.93
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	255,022,137.47	255,022,137.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,532,000.00	17,075,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,532,000.00	17,075,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	286,905,882.36	399,131,287.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,905,882.36	399,131,287.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	260,820,365.30	383,054,464.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,695,493.40	267,166,403.00
210101	Үндсэн цалин	116,911,911.87	157,496,937.00
210102	Нэмэгдэл	37,882,481.53	69,332,539.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,428,000.00	18,194,345.51
210104	Урамшуулал	15,475,100.00	22,142,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,975,100.00	33,420,000.00
210201	Тэтгэврийн даатгал	15,623,000.00	22,725,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,838,100.00	2,673,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,470,400.00	1,336,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	367,700.00	1,336,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,675,900.00	5,347,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,518,964.94	8,715,444.20
210301	Гэрэл, цахилгаан	2,444,352.42	1,889,002.92
210302	Түлш, халаалт	7,581,201.60	6,383,528.64
210303	Цэвэр, бохир ус	493,410.92	442,912.64
2104	Хангамж, бараа материалын зардал	8,178,399.88	6,981,153.58
210401	Бичиг хэрэг	2,080,900.00	3,455,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	1,874,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,163,979.88	1,306,781.58

210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,833,520.00	344,452.00
2105	Нормативт зардал	72,500.00	1,620,000.00
210502	Хоол, хүнс	72,500.00	1,620,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,412,450.00	5,317,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	4,412,450.00	5,317,650.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	2,692,400.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	2,692,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,604,416.00	17,291,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,237,600.00	14,847,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	247,000.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,420,000.00
210807	Газрын төлбөр	183,816.00	183,816.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,863,041.08	39,850,148.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,763,030.00	18,424,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,100,011.08	21,426,038.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,085,517.06	16,076,822.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,972,482.00	13,127,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		5,489,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,204,482.00	7,638,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	589,368.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	589,368.99
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	113,035.06	2,359,753.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,035.06	2,359,753.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,639,828.24	40,937,047.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	46,639,828.24	40,937,047.32



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	302,552,627.47	393,553,499.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,998,490.00	23,995,520.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,998,490.00	23,995,520.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,998,490.00	23,995,520.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,698,490.00	23,995,520.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,300,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	274,554,137.47	369,557,979.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	255,022,137.47	352,482,979.93
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	255,022,137.47	352,482,979.93
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,532,000.00	17,075,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,532,000.00	17,075,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	278,955,371.28	377,263,879.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,955,371.28	377,263,879.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,869,854.22	361,187,056.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,695,493.40	267,166,403.00
210101	Үндсэн цалин	116,911,911.87	157,496,937.72
210102	Нэмэгдэл	37,882,481.53	69,332,539.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,428,000.00	18,194,345.51
210104	Урамшуулал	15,473,100.00	22,142,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,975,100.00	33,420,000.00
210201	Тэтгэврийн даатгал	15,623,000.00	22,725,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,838,100.00	2,673,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,470,400.00	1,336,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	367,700.00	1,336,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,675,900.00	5,347,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,518,964.94	8,715,444.20
210301	Гэрэл, цахилгаан	2,444,352.42	1,889,002.92
210302	Түлш, халаалт	7,581,201.60	6,383,528.64
210303	Цэвэр, бохир ус	493,410.92	442,912.64
2104	Хангамж, бараа материалын зардал	4,356,279.88	8,225,581.58

210401	Бичиг хэрэг	462,800.00	3,251,050.00
210402	Тээвэр, шатахуун	2,120,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,163,979.88	1,306,781.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	509,500.00	1,867,750.00
2105	Нормативт зардал	142,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	142,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,184,000.00	5,999,802.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,284,000.00	-
210604	Урсгал засвар	8,900,000.00	5,999,802.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	2,692,400.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	2,692,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,820,016.00	29,387,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,453,200.00	26,943,610.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	247,000.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,420,000.00
210807	Газрын төлбөр	183,816.00	183,816.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,677,300.00	5,580,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,677,300.00	5,580,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,035,517.06	16,076,822.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,972,482.00	13,127,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,489,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	25,204,482.00	7,638,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	589,368.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	589,368.99
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	113,035.06	2,359,753.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,035.06	2,359,753.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,597,256.19	16,289,620.36
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (iv)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,459,600.00	16,434,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,459,600.00	16,434,200.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	23,459,600.00	16,434,200.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	23,459,600.00	-

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,459,600.00	16,434,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(23,459,600.00)</u>	<u>(16,434,200.00)</u>
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	137,656.19	(144,579.64)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,923.45	144,579.64
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	144,579.64	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,893,504.40	792,100,263.59	1,022,435.00	975,016,203.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,893,504.40	792,100,263.59	1,022,435.00	975,016,203.68
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	46,639,828.24	46,639,828.24
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,893,504.40	792,100,263.59	47,662,263.93	1,021,656,031.92
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,893,504.40	792,100,263.59	47,662,263.93	1,021,656,031.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,893,504.40	792,100,263.59	47,662,263.93	1,021,656,031.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	40,937,047.32	40,937,047.32
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,893,504.40	792,100,263.59	88,599,311.25	1,062,593,079.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,558,000.00	390,748,956.78	(2,809,043.22)	99.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,558,000.00	390,438,956.78	(2,809,043.22)	99.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,424,500.00	377,621,256.78	(2,803,243.22)	99.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,360,500.00	267,166,403.00	(194,097.00)	99.93
210101	Үндсэн цалин	159,792,000.00	157,496,937.72	(2,295,062.28)	98.56
210102	Нэмэгдэл	75,253,700.00	69,332,539.77	(5,921,160.23)	92.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,050,000.00	18,194,345.51	8,144,345.51	181.04
210104	Урамшуулал	22,264,800.00	22,142,580.00	(122,220.00)	99.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,420,000.00	33,420,000.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,725,600.00	22,725,600.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,673,600.00	2,673,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,336,800.00	1,336,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,336,800.00	1,336,800.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,347,200.00	5,347,200.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,075,000.00	8,715,444.20	(2,359,555.80)	78.69
210301	Гэрэл, цахилгаан	3,263,500.00	1,889,002.92	(1,374,497.08)	57.88
210302	Түлш, халаалт	7,283,500.00	6,383,528.64	(899,971.36)	87.64
210303	Цэвэр, бохир ус	528,000.00	442,912.64	(85,087.36)	83.88
2104	Хангамж, бараа материалын зардал	8,354,300.00	8,225,581.58	(128,718.42)	98.46
210401	Бичиг хэрэг	3,800,000.00	3,251,050.00	(548,950.00)	85.55
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,306,781.58	406,781.58	145.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,300.00	-	(54,300.00)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,867,750.00	67,750.00	103.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,454,700.00	22,434,002.00	(20,698.00)	99.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,454,700.00	11,434,200.00	(20,500.00)	99.82
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,999,802.00	(198.00)	100.00
2107	Томиллолт, зочны зардал	2,700,000.00	2,692,400.00	(7,600.00)	99.72
210702	Дотоод албан томиллолт	2,700,000.00	2,692,400.00	(7,600.00)	99.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,460,000.00	29,387,426.00	(72,574.00)	99.75

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,991,000.00	26,943,610.00	(47,390.00)	99.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	240,000.00	(10,000.00)	96.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	1,420,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	199,000.00	183,816.00	(15,184.00)	92.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.00	5,580,000.00	(20,000.00)	99.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.00	5,580,000.00	(20,000.00)	99.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,133,500.00	13,127,700.00	(5,800.00)	122.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,133,500.00	13,127,700.00	(5,800.00)	122.41
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,495,500.00	5,489,700.00	(5,800.00)	99.89
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,638,000.00	7,638,000.00		100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	393,558,000.00	390,604,377.14	(2,953,622.86)	100.01
12	Төсөвт байгууллагын өөрийн орлого	24,000,000.00	23,995,520.00	(4,480.00)	99.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,000,000.00	23,995,520.00	(4,480.00)	99.98
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	352,483,000.00	351,893,610.94	(589,389.06)	99.87
122005	Улсын нутгийн төсвөөс	352,483,000.00	351,893,610.94	(589,389.06)	99.87
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,075,000.00	14,715,246.20	(2,359,753.80)	86.18
122005	Орон нутгийн төсвөөс	17,075,000.00	14,715,246.20	(2,359,753.80)	86.18
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	144,579.64	144,579.64	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	19.00	19.00		100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9.00	9.00		100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00		100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00		100.00
65	ОРОН ТООНЫ	9.00	9.00		100.00

ХТ05498 @ 9822899

	МЭДЭЭЛЭЛ				
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	7.00	7.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	2.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус Музей Монголын болон орон нутгийнхаа эрт, эдүгээ үеийн түүх, байгалийн болон угсаатны өв соёлын түүхийг дэлгэн үзүүлэх, хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэх, судлан сурталчлах танин мэдэхүйн болон соёл, судалгаа шинжилгээ хийх зорилго бүхий төрийн үйлчилгээний соёлын байгууллага юм.

Үйл ажиллагааны зорилгын хүрээнд аймгийн болон сумдын Түүх Соёлын Үл Хөдлөх болон Хөдлөх Дурсгалын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж бүртгэн баримтжуулах, Биет Бус Соёлын Өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах, сан хөмрөгийн баяжуулах зэргээр тодорхой үе шаттайгаар бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэн ажилладаг. Мөн өдөр тутам үзэгчдэд мэдээ мэдээлэл, тайлбар сурталчилгааны үйлчилгээ явуулахаас гадна Музейг сургалтын орчин болгох зорилт тавьж ажилласнаар Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эх түүх, орон нутаг судлал, газар зүй, дүрслэх урлаг, уран зохиол, байгаль шинжлэлийн хичээлүүдээр олон талт сургалтын хөтөлбөр гарган Музейн орчинд зохион явуулдаг уламжлалтай. 2024 онд орчин цагийн Музей үүсэж хөгжсөний 100жилийн ойг угтан Дарханы түүх, соёл эрт эдүгээ эрдэм шинжилгээний хурал, мөн хурлын эмхтгэлийг ISBN 9789919040637 код авч албажуулсан байна. Музей нь 2024 онд нийт 463 удаагийн үзвэр үйлчилгээг зохион байгуулж 44735 хүнд хүрч үйлчилсэн байна. Мөн боловсролын хөтөлбөрийг 418 удаа зохион байгуулж 10919 оролцогч хамруулсан байна. Нийт 17 удаагийн түр үзэсгэлэн зохион байгуулснаас 12 дотоодын 5 хамтарсан үзэсгэлэнг нийт 14,766 үзэгчид толилуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Музейн сан хөмрөг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, эрдэм шинжилгээ судалгаа хийх, хүүхэд залуучуудад олон нийт, соёлын өвийн боловсролын хөтөлбөр явуулахад МУ-ын Үндсэн хууль, Музейн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Музейн холбогдох дүрэм, журам, стандарт зэрэг эрх зүйн орчноор үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 05 дугаар сарын 04-ны 10 дугаар тогтоол "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх
- Монгол улсын засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны 488 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод

хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх

- Монгол улсын засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны 491 дүгээр тогтоол “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх
- Монгол улсын сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны 211 дүгээр тушаал “Эдийн засгийн ангилал шинэчлэн батлах тухай”
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох” тухай 240, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241-р тогтоолуудыг мөрдөж ажилласан.
- Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн журам шинэчлэн батлах тухай” тушаалыг 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс мөрдөж ажиллах
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн боловсруулсан бодлогын бичиг баримтын хүрээнд мөрдөж ажиллаж байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн музейн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тогтоолоор батлагдсан дундаж цалин хөлс тодорхойлох журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,937.0 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	144.6	-	144.6
Авлага	-	-	-
Бараа материал	7,770.9	7,329.5	441.4
Үндсэн хөрөнгө	1,013,740.5	1,055,263.5	41,523.0
Нийт хөрөнгө	1,021,656.0	1,062,593.0	40,937.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,021,656.0	1,062,593.0	40,937.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,021,656.0	1,062,593.0	40,937.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй болж улсын төсвөөс 589.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 2,359.48 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг татагдсан байна. Тухайн байгууллагын цалингийн сангаас 194.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2,113.0 мянган төгрөг, Хангамж, бараа материалын зардлаас 128.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,329.5 мянган төгрөг болж төсвийн хөрөнгөөр 157.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 28,157.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд үйл ажиллагаанд 28,598.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,055,263.5 болж 62,949.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 16,434.2 мянган төгрөгөөр худалдан авч 17,650.0 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар ирсэн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 28,214.8 мянган төгрөг, дахин үнэлгээгээр 650.0 мянган төгрөг буюу нийт 62,949.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 6,718.4 мянган төгрөгийн хөрөнгө актлаж устгасантай холбоотой

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,062,593.0 мянган төгрөг болж 40,937.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 352,482.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 23,995.5 мянган төгрөг, нийт зарлагыг 393,558.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 138,960.9 мянган төгрөгөөр бууруулж, 352,482.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслийн тусгасан дүнгээс тоног төхөөрөмж, тавилга, судалгааны ажлын зардал тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг Гүйцэтгэлээр улсын төсвөөс 351,893.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 14,715.2 мянган төгрөг үндсэн үйл ажиллагааны орлого 23,995.5 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 390,651.4 мянган төгрөг буюу 98,45 хувьтай тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71702 соёл урлаг	1	80101- Үндсэн уйл ажиллагааны зардал	328,207.3	317,763.6	10443.7	96.8
		2	80215- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардал	10,000.0	10,000.0	-	100.0
		3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	7,638.0	7,638.0	-	100.0
		4	83603- Дээд шатны төсвөөс хуваарилсан	24,000.0	23,995.5	4.5	99.98
		5	81855- гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	16,637.7	16,636.6	1.1	99,9
		6	80111-байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	17,075.0	14,715.2	2,359.8	94.80
Нийт				393,558.0	390,748.9	12,809.1	99.28

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аймгийн Музей нь 2024 онд нийт соёлын яамнаас батлагдсан нийт 9 орон тоогоор гүйцэтгэл гарч ажилласан байна. Худалдан авах ажиллаанд нийт таван бараа ажил үйлчилгээний зардалд 38,919.7 мянган төгрөг батлагдсанаас таван бараа ажил үйлчилгээг нийт 38,919.7 мянган төгрөгийн зардлыг шууд худалдан авалтаар зарцуулан tender.gov.mn сайтад төлөвлөгөө болон тайланг тайлагнасан байна. Шилэн дансанд нийт 171 мэдээ мэдээлэл оруулж байршуулахаас бүгд мэдээлэл мэдээллэгдсэн болно.Бараа үйлчилгээний зардал , болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд нийт 32,591.0 мянган төгрөг төсөвлсөнөөс 31,967.4 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл бичих

2024 онд 6,969.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 4 төсөл боловсруулж төлөвлөсөн. Бичиг хэргийн зардал 1,800.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардал 1,800.0 мянган төгрөг, шуудан холбооны зардал 900.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардал 2,469.0 тус тус шууд

худалдан авалтаар тус тус зарцуулсан. Нээлттэй сонгон шалгаруулалтын тендер байхгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Музей нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 286,905.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,736.1 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй хэмнэлттэй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 153 мэдээллээс огт мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Музейн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, акт, албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье